

**ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 2 ДУГААР САРЫН 2 ДАХЬ  
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА**

№

2018.02.08

Өлгий сум

**Нэг: Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал.**

Тус Цагдаагийн газар өнгөрсөн 7 хоногийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 49 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд 5 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн.

Мөн 4 гомдол, мэдээлэлд хэрэг нээхээс татгалзсан.

Хулгайлах хэрэг 3, хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг -, бусад төрлийн 2 хэрэг тус тус бүртгэгдсэн.

Нийт 198 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 183 хүнд 9.545.000 төгрөгийн тогуулийн шийтгэл оногдуулсан, 3 хүн баривчлагдсан, 12 хүн эрүүлжүүлэгдсэн.

**Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ.**

1. “Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх аймгийн дунд хугацааны дэд хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

2. Сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түшиглэн зохион байгуулах, иргэд, олон нийтэд холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах зорилгоор “Гэмт хэрэг, зөрчилгүй сум” аяны төлөвлөгөөг боловсруулан 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргаар батлуулсан. Аян бүтэн жилийн хугацаанд хэрэгжинэ.

3. Тус Цагдаагийн газраас санаачилан зохион байгуулсан бяцхан Е.Айсултан хүүгийн эмчилгээний зардалд туслах зорилгоор сэтгэлийн хандивын аянг зохион байгуулсан.

Аймгийн прокурорын газар, Зэвсэгт хүчний 340 дүгээр анги, Аймгийн Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шинжилгээний алба, Баян-өлгий аймаг дахь Харьяатын албаны алба хаагчдаас нийт 875.840 /найман зуун далан таван мянга найман зуун дөч /төгрөгийг Е.Айсултан хүүгийн эмчилгээний зардалд хандив тусламж үзүүлсэн.

4. Хулгайлах гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түшиглэн зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн төвлөрсөн худалдааны захын захиралуудтай 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр “Итгэлцлийн гэрээ” байгууллаа.

5. Аймгийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр сард 31 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 7 хэрэг буюу 18.4 хувиар буурсан үзүүлэлт гарсан.

6. Төрийн байгууллагын харуул хамгаалалтын байдал хийсэн хяналт шалгалтын танилцуулгыг аймгийн Засаг даргад 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 36/353 дугаар албан тоотой хүргүүлсэн.

ЦАГДААГИЙН ГАЗАР